



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 119 ЧАГ-САГ/2013/СТА-ЗГАНТ

Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хуримтлалын сангийн хөрөнгөөр ҮХААЯ-ны захиалгаар Төв аймгийн Угтаал цайдам сум дахь 36,000 тн багтаамжтай үр тарианы элеватор сэргээн засварлах ажлыг 3,667,829,679 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Сангийн яам, "Цаст Констракшн" компаний хооронд 2012 оны 7 дугаар сарын 04-ний өдөр ТШ/12/03/01/-ХББТ дугаар гэрээ байгуулсан байна.

Сангийн яамнаас гэрээний дагуу хийх санхүүжилт /нэмэлт зардлын хамт 3,957,244,772.20 төгрөг/-ийг "Цаст Констракшн" компанид бүрэн төлж дуусган Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэлд Гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалтын зардлаар тусган тайлагнасан боловч Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ҮХААЯ-ны 2012 оны жилийн эцсийн аудит хийгдсэн санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 7.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ", 9.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана", 10.3-д "Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлсэн томоохон үйл явдлын тухай тодруулга, тайлбар, аудиторовын дүгнэлт, удирдлагын тайланг хавсаргана" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

"Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн дараах Албан шаардлагыг өгч байна.

Дээр дурдсан хөрөнгө оруулалтын зардлын 3,957,244,772.20 төгрөгийг Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ҮХААЯ-ны санхүүгийн тайланд тусгуулж, холбогдох шийдвэрийг үндэслэн эдгээр байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР



Г.ЮРА